



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/480

Мандалговь

Г "Хандлагыг өөрчилж-хамтдаа хөгжье"
чуулга уулзалтанд хөрөнгө гаргах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 15 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд "ХАНДЛАГЫГ ӨӨРЧИЛЖ-ХАМТДАА ХӨГЖЬЕ" хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалтыг 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

Хоёр. Чуулга уулзалтын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Г.Хишигдаваа)-д үүрэг болгосугай.

Гурав. Чуулга уулзалтад шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010516